



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/199

Бор-Өндөр сум

**Эрсдэлийн сангаас хөрөнгө зарцуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.1, 32.1.6 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Бор-Өндөр 1-р багийн 42-р байрны дээвэр хууларч оршин суугчдаас ирсэн гомдлын дагуу шалгаж үзэн дээврийг засварлах шаардлагатай тул 3.800.000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай

2. Дээвэр засварын ажилд зарцуулагдах 3.800.000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Эрсдэлийн сангаас зохих журмын дагуу тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.АДЪЯАБИЛЭГТ